



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/2021

Мандлговь

Г 2018 онд гаргах уст цэгийн нэр, 7
байршил батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3 "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6, аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 4.1.2 дахь заалт, гүн өрмийн машин, тоног төхөөрөмж түрээслэгч Элбэг санчир ХХК-тай 2018 онд байгуулсан гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малчдаас ирсэн хүсэлтийг харгалзан, бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2018 онд шинээр гаргах гүн өрмийн инженерийн хийцтэй худгийн байршил, нэрийг нэгдүгээр, худаг гаргаж буй явцад хяналт тавьж, хүлээж авах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Байгуулсан худгийг акт үйлдэн, хүлээж авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (Ж.Мөнхчулуун)-т даалгасугай.

Гурав. Гэрээний дагуу инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг чанартай, бүрэн гүйцэд хийж, гүйцэтгэн ажлын хэсэгт хүлээлгэн өгөхийг "Элбэг санчир" ХХК (О.Хүүхэнбаатар)-т, худгийн ашиглалт, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200656

Аймгийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 25-ны
 өдрийн /2018/ дот захиралжийн 1-р хавсралт

2018 онд гаргах инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн нэр, байршил

№	Сумын нэр	Эзэмших малчны нэр	Баг	Газрын нэр	Тухайн газарт байгаа		БИНХурлаар хэлэлцүүлсэн огноо
					малчин өрхийн тоо	малын тоо	
1	Гурвансайхан	Б.Зулзага	1-р баг	Бумбатын гол овоо	11	5558	2018.04.19
2	Хулд	Цог-Очир	4-р баг	Дөшийн жирэм	7	5000 гаруй	2018.01.10
3	Говь-Угтаал	Д.Түвшинбаяр	2-р баг	Агзын ар	5	5600	
4	Дэрэн	Дэрэн ОНӨҮГ			Малын тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор		
5	Сайнцагаан	Ц.Отгонбаяр	Наран баг	Нарангийн төв	11	6526	2018.03.23
6		Ё.Охиноо	Наран баг	Урд хонхор	10	3607	2018.03.23
7	Дэлгэрхангай	Н.Амартүвшин	3-р баг	Улаанхамар	7	6850	2018.05.11
8	Эрдэнэдалай	Б.Дащдондов	3-р баг	Бор хошуу 40км	8	6700	2017онд
9	Луус	Н.Баясгалан	Суварга баг	Сумаас зүүн хойш-52 км	7	4000	2018.01.19
10	Сайхан-Овоо	Г.Өлзийбаяр	2-р баг	Шинэ-Ус	7	3000	2018.04.04
11	Дэлгэрцогт	С.Жаргалсайхан	2-р баг	Молмын ухаа	10	9000	2018.05.03
	Нийт						

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 25-ны
өдрийн /1001/ тоот захирамжийн 2-р хавсралт

Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг хүлээж авах ажлын хэсгийг дараах
бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхчулуун /Аймгийн Засаг даргын орлогч/

Нарийн бичгийн дарга: Ж.Шинэ-Уянга /ХХААГ-ын мэргэжилтэн/

Гишүүд: /ХОХБТХэлтсийн мэргэжилтэн/

Б.Цэрэнсугир /БОАЖГ-ын мэргэжилтэн/

Холбогдох сумдын Засаг дарга нар